

ТАНИЛЦУУЛГА

Соёлын тухай хуулийн шинэчилсэн
найруулгын төсөл

Соёлын тухай хуулийг 1996 онд баталснаас хойш 14 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль нь Монгол Улсад соёлын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэслэл, удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг түлхүү зохицуулж байна.

Улс орны хөгжилд соёлын гүйцэтгэх үүрэг дэлхий нийтийн түвшинд төдийгүй бүс нутаг, үндэсний хэмжээнд өсөн нэмэгдэж, даяаршлын хөгжлийн хандлагыг даган орчин үеийн дижитал технологийн дэвшил соёл урлагийн хүрээнд нэвтэрч байна.

Үүнтэй зэрэгцэн Монголд бусад улсын соёл хүч түрэн нэвтэрч, түүнд залуу үе татагдан дагах явдал газар авч байгаа төдийгүй, хотжилт хүн амын төвлөрөл нь үндэсний язгуур урлаг, соёлыг уусган өөрчлөх хандлага бий болоод байна.

Дэлхий нийтийг хамарсан даяаршлын үйл явцын эрчимтэй нөлөө, үндэстэн дамнасан соёл хоорондын харилцааны идэвхтэй хөгжил, дэлхий дахины болон улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд явагдаж байгаа хурдацтай өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч соёл, урлагийн салбарыг хөгжлийн шинэ шатанд гаргах зорилгоор Соёлын тухай хуулийг шинэчлэн батлуулах шаардлагууд үүссэн байна.

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.42-т “Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, хуулийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ын 57-д “Соёлын тухай хууль 1996 онд батлагдсанаас хойш шинэчлэгдээгүй бөгөөд уг хуулийн зохицуулалт нь соёл, урлагийн өнөөгийн харилцааг зохицуулах, цаг үеийн шаардлагыг хангахгүй болсон тул хуулийн зохицуулалтыг шинэчилж боловсронгуй болгох” гэж заасан.

Соёлын тухай хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлж үндэсний аюулгүй байдлын баталгааг хангах, аль нэг соёлын дарангуйлалд өртөхгүй байх, өөрийн уламжлалт зан заншил, соёлын давтагдашгүй байдал, онцлогийг хадгалан үлдэх, иргэдийн соёлын мэдлэгийг дээшлүүлэх, боловсролын тогтолцоогоор дамжуулан эх оронч үзэлтэй, үндэсний бахархал, соёлын өв, уламжлал, ёс заншилаа дээдэлсэн, монголчуудын үнэт зүйлсийн уламжлал, шинэчлэлийг зохистой хослуулсан иргэнийг төлөвшүүлэх шаардлага үүссэн.

Мөн соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний агуулга, бренд үйлдвэрлэлийг зах зээлд нэвтрүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоох, шинэ мэдлэг, шинэ технологи дамжуулах механизм нэвтрүүлэх нь чухал байна.

Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараахь зохицуулалтыг тусгалаа:

- хуулийн нийтлэг үндэслэл болох хэсэгт хуулийн зорилтыг тодорхойлж, соёлын тухай хууль тогтоомж, соёлын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтоож, зарим нэр томъёог жигдэллээ;

- соёлын үйл ажиллагаа явуулах чиглэлийг “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенци”, “ЮНЕСКО-гийн соёлын статистикийн хүрээ”-нд нийцүүлэн зааж, соёлын үйл ажиллагаанд оролцох, эрхлэх, соёлын байгууллагын чиг үүрэг, удирдлага, үндэсний соёлын байгууллага, ажилтны эрх, үүргийг зааж, соёл судлал, соёлын боловсрол олгох зохицуулалтыг бий болголоо;

- соёлын салбарын удирдлага, зохион байгуулалт, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, үндэсний зөвлөлийн эрх, үүргийг тодорхойлсон;

- соёлын байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч соёлын эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мэргэжлийн урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, түүнээс олсон нийт орлого нь санхүүжилтийн гол эх үүсвэр болгох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн. Соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотойгоор мерчандайзын гэрээний зохицуулалтыг тусгаж өгсөн;

- соёлын агентын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, үйл ажиллагаан дахь хязгаарлалт, хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт, хариуцлагын асуудлыг тусгасан.

-Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 6 бүлэг 25 зүйлтэй бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Соёлын тухай хуулийн 70 шахам хувь нь өөрчлөгдөж, нэр томъёо, соёлын үйл ажиллагааны чиглэл шинэчлэгдэн, баримтлах зарчим, соёл судлал, соёлын боловсрол, үйлдвэрлэл, ажилтны үнэлэмж, мерчандайзын гэрээ, агентын зохицуулалт шинээр нэмж тусгагдсан.

Хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үндэсний өв соёлтой танилцаж, Монгол хүн болж төлөвшихөд чухал үүрэг бүхий соёлын боловсрол олгох үйл ажиллагааны чухал хэсэг болох музейн болон Монгол Улсын үндсэн хуульд заасан иргэний суралцах, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах, мэдээлэл, соёлын үйлчилгээ түгээх орон нутгийн номын сан, орон нутаг судлах танхимын мэдээллийн үйлчилгээг 16 хүртэлх насны хүүхдэд үнэ төлбөргүй хүргэхэд нийт 2.3 тэрбум төгрөг шаардлагатай болно.

Мөн соёлын байгууллагын үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэн давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, Соёл судлалын хүрээлэн бий болгох зэрэг хуулийн хэрэгжилтийг хангахад улсын төсөвт жилд дунджаар **9.2** тэрбум төгрөгийн төсвийн эх үүсвэр нэмэгдүүлэх шаардлагатай тооцоо хийгдсэн байна.

Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан Соёлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар иргэдийн соёл, урлагийн боловсрол дээшлэх, үндэсний соёл уламжлалаа дээдлэх, хөгжүүлэх дархлаа бий болж, соёлын үйл ажиллагаан дахь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.

Соёлын үйлчилгээ, хүртээмж сайжирч, уран бүтээл хийх сэдэл бий болгох, соёл, урлагийн үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдэх, үндэсний соёлыг хадгалах, хамгаалах, судлах, соёлын олон улсын хамтын ажиллагааг дэмжих, соёл урлагийн салбарт мэргэжлийн болон шинжлэх ухааны судалгааг нэвтрүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.

Иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн театр, чуулгын урын санг үндэстэн, ястны онцлогтой уялдуулан хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Уран бүтээлийг бодитойгоор урт хугацаанд дэмжих, соёлын харилцаанд оролцогчдын хөдөлмөрийг зүй зохистой үнэлж, хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР